

# **Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил ба төвлөрөл**

## **Media ownership and concentration**

**М.Доржханд  
хуульч**

**Яагаад хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил,  
төвлөрлийн асуудал тулгамдсан асуудал болж байна  
вэ?**

- Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг бид хэрхэн үнэлж байна вэ?
- **Зөв үнэлэх тухай ойлголтыг Ойлгох нь чухал.**
- **Ойлгохгүй бол хөтлөгдөнө.**
- Үнэлж ойлгосон тохиолдолд л хамгийн **зөв сонголт** хийх боломжтой болно.

# Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин

- Үндсэн хууль
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Радио долгионы тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль

# Үргэлжлэл

- Үзэл баримтлал батлах тухай УИХ-ын 2000 оны 21 дүгээр тогтоол
- *Харилцаа холбооны зохицуулах хорооны 2009 оны 40 дүгээр тогтоолын хавсралт*
- Монгол Улсын харилцаа холбооны зохицуулах хороо харилцаа холбооны зохицуулах хорооны 2009-2012 оны үйл ажиллагааны стратеги
- НҮБ-ийн хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1974
- Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (1996-2002)

# Анализ

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөх, эзэмших асуудал байж болох эсэх, түүнийг зөвшөөрөх эсхүл хориглох, ил тод болгох хууль эрх зүйн орчин байхгүй.

# Үргэлжлэл

- Харилцаа холбооны тухай хуулийн дагуу зохицуулах газрын бүрэн эрхийн асуудал тодорхойгүй, шударга өрсөлдөх нөхцлийг хэрхэн бүрдүүлэх, ямар стандарт барих нь тодорхойгүй,
- Зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хэрхэн хянах нь мөн л тодорхойгүй.

# Үргэлжлэл

- Өрсөлдөөний тухай хуульд Зах зээлийн төвлөрөл гэх ойлголтыг тодорхойлсон боловч хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн төвлөрлийн асуудлыг хэрхэн үүнд нийцүүлэн зохицуулах нь ойлгомжгүй.
- Харилцаа холбооны зохицуулах газар болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын чиг үүрэг нь давхцсан.

# Ойлголт, онолын асуудал

Хэрхэн сонголт хийх вэ?

1. Судалгаа

2. Зохицуулалт

3. Зохицуулах, хэрэгжилтийг  
хянах чиг үүрэг



# Үргэлжлэл

- Судалгаа: эргэлзээтэй, улс төрийн нөлөөлөл.
- Зохицуулалт:
  - Хуулийн: олон улсын, дотоодын,
  - Зөвшилцлийн зохицуулалт
- Зохицуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих:
  - олон нийтийн байгууллага,
  - төрийн эрх бүхий байгууллага

**Хэвлэл мэдээллийн хараат бус байдалд  
эзэмшлийн асуудал нөлөөлнө.**

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн  
эзэмшил: **Хөндлөнгийн  
оролцоо, Төвлөрөл**
- Төвлөрөл: уламжлалт буюу  
бүтцийн нэгдэл, орчин үеийн  
буюу зах зээлийн нэгдэл

# Өмчлөл? Эзэмшил?

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл
- Эзэмшил – лиценз буюу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үүсч бий болдог ойлголт

# **Ашгийн сонирхол (АС) – Олон нийтийн эрх ашиг (ОНЭА)**

- **Зохимжтой тэнцвэрт байдлыг хангах хэрэгтэй.**
- **Үр дүнд нь: Шударга өрсөлдөөнд тулгуурласан зах зээл (АС), нээлт, шинэлэг байдал, хөгжил (ОНЭА)**
- **Ашгийн сонирхол: эзэмшил, төвлөрөл, хазаарлагч нь ил тод байдал, олон талт үзэл буюу плюрализм байна.**

# Үргэлжлэл

- ОНЭА: мэдээлэл олж авах эрх, хэвлэн нийтлэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ил тод (transparency) байдал, Хазаарлагч нь шударга өрсөлдөөний зохицуулалт, интернэтийн хөгжил, улс төрийн ашиг сонирхол байна.

# Зарим улсуудын зохицуулалтаас...

## Франц Улс

- 1986 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулинд ил тод байдалтай холбоотой мэдээллийг олон нийтэд ил болгосон байх ёстой:
  - Хэрэв тухайн компанийг хувь хүн эзэмшдэг бол эзэмшигч(ид), хамтран эзэмшигч(ид)-ийн овог нэр(үүд)
  - Хэрэв тухайн компани нь хуулийн этгээд бол компаний нэр, байршил, эрхзүйн баримт, хуулийн төлөөлөгчид болон гурван гол ажилтны нэр
  - Бүх тохиолдолд хэвлэл захирлын болон хянан тохиолдуулах ажлыг хариуцсан хүмүүсийн нэр
  - Хянан тохиолдуулсан хэвлэл нийтлэлийн жагсаалт болон тухайн компаний оролцдог хэвлэл мэдээллийн бусад (дүрс, дуу бичлэгийн) үйл ажиллагааны жагсаалт

# Үргэлжлэл

- Компаний данс тайланг ил болгох шаардлагууд
- Хувьцаа, капитал хөрөнгө болон хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлтийг зохицуулах хороо, албанд мэдэгдэх шаардлагууд

# Үргэлжлэл

- 1994 оны Радио телевизийн тухай Хуульд зааснаар хувь хүн, хуулийн этгээд нь телевизийн үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй компаний сонгох эрхийн капиталын 49%-ийг эзэмших хязгаартай байдаг. Телевизийн лицензтэй хоёр дахь компанийн сонгох эрх болон капиталын 15%-ийг, гурав дахь компаний 5%-ийг эзэмшиж болно гэж тогтоосон байдаг.



# Үргэлжлэл

- Гэхдээ (бүс нутгийн болон орон нутгийн) нийт үйлчилгээ нь энэ тохиолдолд 6 сая хүртэлх үзэгчдэд хүрч болох хязгаартай байдаг. Кабелийн телевизийн хувьд үндэсний эсвэл бүс нутгийн хэмжээнд 8 сая хүртэлх үзэгчидтэй байх хязгаартай байна.

# Үргэлжлэл

## Гадаадын эзэмшлийн дүрэм журам

- Гадаадын хөрөнгө оруулагчид франц хэлээр нэвтрүүлэг цацдаг эсвэл хэвлэн нийтэлдэг хэвлэл мэдээллийн компаний капитал буюу сонгох эрхийн 20 хүртэлх %-ийн хувьцааг эзэмших хязгаарлалт байдаг.

- Холбооны шүүхийн санал болгосны дагуу хэвлэл мэдээллийн **төвлөрлийг** мэдээллийн эрх чөлөөнд заналхийлдэг гэж үздэг учраас **эзэмшлийн** тухай хууль тогтоомж санал болгожээ. Гэхдээ мужууд эдгээр саналыг төдий л сайшаан хүлээн аваагүй байна.

# Үргэлжлэл

- 1996 оны Радио телевизийн муж хоорондын хэлэлцээр-ээр үндэсний радио телевизийн зөвшөөрөл лиценз олгох, хянах (мөн агуулгыг) зорилгоор Хэвлэл мэдээллийн салбарын Төвлөрлийг хянан шалгах хороог байгуулжээ. Мужийн хуулийг зөрчсөн аливаа тохиолдолд тус хороо нь лицензийг хүчингүй болгох эрхтэй.
- Холбооны Картелийн Алба нь давамгайл байр суурийг хууль бусаар ашиглах асуудлыг хянаж зохицуулдаг.

# Итали Улс

- 1981оны Хэвлэл мэдээллийн тухай хуулийн Нэгдүгээр бүлэгт заасны дагуу хэвлэлийн газрууд сонин сэтгүүлээ *Харилцаа холбооны операторуудын бүртгэлд* (орон тооны 5-аас дээш сэтгүүлчтэй) бүртгүүлэх ёстой ба *Харилцаа Холбооны Албанд* жил бүр хуулинд заасан шаардлагуудын дагуу санхүүгийн тайлан гаргаж өгөх ёстой.

# Үргэлжлэл

- 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулинд заасан) зах зээлийн хувь хэмжээний тухай дүрэм журмаар хэвлэлийн газрууд борлуулалт улсын хэмжээнд 20%, бүс нутгийн хэмжээнд 50% байх хязгаартай байдаг.

# Үргэлжлэл

- 1987 оны Хэвлэлийн хуулинд хэвлэлийн газар монополь байр суурьтай болсон тохиолдолд Парламент тухайн компаний хувьцааг хүчингүй болгох эрхтэй гэж заажээ (уг байдлыг засахад компанид 6-12 сарын хугацаа өгдөг).

# Нидерланд улс

- Компанийн тухай хуулийн дагуу бүх компаниуд хувьцааны томоохон өөрчлөлтийг олон нийтэд (сонинд) тайлагнах ёстой. Хувьцааны томоохон өөрчлөлт гэдэг нь хувьцаа эзэмшигч компаний хувьцааны 5, 10, 25,50 ба 66 хувьд хүрэхийг хэлнэ.



# Үргэлжлэл

- 1990 оны Хэвлэл мэдээллийн хуулинд 60%-иас дээш үзэгчтэй радио телевиз улсын хэмжээнд 25%-иас дээш уншигчдад хүрдэг сонин эзэмших эрхгүй гэсэн хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшлийн тухай заалтууд орсон байдаг.

# Их Британи

- Хэвлэлийн газруудын орон нутгийн борлуулалт нь 20%-иас бага (олон нийтийн ашиг сонирхлын тестээр шалгана) бол орон нутгийн 3 радиогийн лиценз эзэмшиж болдог. Орон нутгийн борлуулалт нь 20-50%-тай орон нутгийн сонин нэг FM радиогийн станц, нэг AM радиогийн станц эзэмшиж болно.

# Америкийн Нэгдсэн Улс

- Сонин/Радио телевиз давхар эзэмшихийг хориглосон дүрэм (1975)
- Тухайн сонины хэвлэн нийтэлдэг хот нь радио телевизийн сувгийн үйлчилгээний бүс нутагт хамаардаг бол бүрэн ажиллагаатай радио телевизийн суваг болон өдөр тутмын сонин давхар эзэмшихийг хориглодог.

# Үргэлжлэл

Радио/телевизийн давхар эзэмшлийн хориг  
(1970)

- Нэг зах зээл дээр дор хаяж нэг телевиз ба нэг радиогийн суваг зэрэг эзэмшихийг зөвшөөрдөг. Томоохон зах зээлүүдийн хувьд тухайн зах зээл дээр хэдэн хувийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байна гэдгээс шалтгаалан нэг хуулийн этгээд нэмэлт радио станцууд эзэмшиж болдог.

# Австрали улс

- Лицензийн нийт хамрах хүрээ нь Австрали улсын нийт хүн амын 75-аас дээш хувийг хамарсан телевизийн лицензийг эсвэл лиценз бүхий газар нутагт нэгээс олон лицензийг хувь хүн эзэмших эрхгүй байдаг. Гадаадын иргэд лицензтэй компанид удирдах албан тушаал хаших ёсгүй бөгөөд гадаадын нийт хувь оролцоо 20%-иас хэтэрч болохгүй.

## Дүгнэлт:

- Ил тод байдлын эхлэл: олон улс нь компанийн нэрийг нэрлэхийг шаарддаг. Гэвч энэ нь эзэмшлийг ил тод болгож байгаа ойлголт биш юм.

# Дүгнэлт

- Мэдээллийг идэвхтэй эрж хайх ёстой бөгөөд олон тооны арга замыг ашиглах ёстой.
- Европын Холбооны зүгээс бүх гишүүн орон өөрийн хил доторх хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн асуудлыг **үнэлэх, хянах чадвартай** байх ёстой гэсэн урьдчилсан шаардлага гаргасан.

# Дүгнэлт

- Европын Холбооны хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмших эрхийг ил тод байлгах тухай заавал дагаж мөрдөх шаардлагагүй зөвлөмжүүд болон дуу дүрс бичлэгийн салбарт хамгийн багадаа ямар ил тод байдал шаардлагатай вэ гэдгийг тогтоосон заавал дагаж мөрдөх дүрэм журам орно.



# Дүгнэлт

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл гэдэгт цөөн тооны компани болон корпораци тэнцүү хувиар зонхилох хэвлэл мэдээллийн хэрэгслийн худалдаалах эрхийн ихэнхийг эзэмшдэг гэсэн ойлголт хамаарагддаг.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл бол олон нийтийн, бүс нутгийн болон тодорхой үндэстний асуудал байсаар байна.

# Зөвлөмж:

Төвлөрөл гэх ойлголтыг Монгол Улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн эзлэх хувь зах зээлд ямар хувь хэмжээнд хүрсэн тохиолдолд төвлөрөл гэх ойлголтод хүрдэг эсэхийг тодорхой заах хэрэгтэй.

- Ил тод байдал, олон ургалч үзэл гэсэн ойлголтууд нь мэдээлэл авах эрхийг хангах гол түлхүүр болох тул хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийг тусгай зөвшөөрлөө авах үед нь дэлгэх шаардлагыг хуульчилж, олон нийтэл ил болгох шаардлагатай.


# Зөвлөмж

- Харилцаа холбооны зохицуулах газар болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын зохицуулах чиг үүргийг уялдуулах, тодорхой болгох
- Зах зээлд эзлэх хувийг Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн зах зээлийн хөгжил, үзэгч, хэрэглэгч, газар нутгийн байршилтай уялдуулах харилцан адилгүй тогтоох учир Харилцаа холбооны зохицуулах газраас тодорхой стандартууд гарган, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийг тогтоох, зохицуулах боломж олдоно.

# Зөвлөмж

Гадаад эзэмшлийн хувьд Монгол Улсад зах зээлийн судалгаа, хэрэглэгчийн тоо, эзлэх хувийг тогтоосны үндсэн дээр гаргах учир хууль тогтоомжийн хүрээнд хориглох шаардлагыг шууд тогтоох боломжгүй юм.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал нь хориглох гэхээсээ илүү тогтоох, тодорхойлох, зохицуулах, хэргэжүүлэх системийг хамгийн зохимжтой байдлаар тусгаснаар Ил тод байдлыг олж авах боломж бүрдэх юм.



Анхаарал  
тавьсанд  
баяралалаа.